

Ж.Мягмардаваа миний бие Орхон аймгийн ИТХ-н сонгуульд бие даан нэрээ дэвшүүлэх хүсэлтээ илэрхийлж, холбогдох хууль, дүрэм, журманд заасны дагуу мөрийн хөтөлбөрөө боловсруулсан. Мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2050 зэрэг хууль тогтоомж, баримт бичгийг удирдлага болгон боловсрууллаа.

**Уриа:**

**1. ОРОЛЦОЁ!**


Бидний оролцоогүй ӨНӨӨДӨР, бидний хүсээгүй МАРГААШИЙГ бүтээж байна.

**2. ӨӨРЧИЛЬЕ!**

Эсвэл энэ хэвээрээ үлдье.

**Тууштай баримтлах бодлого:**

1. Хүртээмжтэй,
2. Оролцоотой,
3. Тогтвортой өсөлтийг хангах.



*Ж.Мягмардаваа*

### **Иргэдийн оролцоотой хот:**

1. Аюулгүй орчинтой, унаган төрхтэй байгалийг хойч үедээ хэвээр өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх
2. "Хотын хөгжил Хорооллоос" төсөл хөтөлбөрийг боловсруулан хувийн болон нийтийн эзэмшилийн гудамж талбайг Аймгийн ЗДТГ болон иргэдийн санал асуулга, санаачилгаар цэцэрлэгжүүлэх ногоон байгууламжийг бий болгон тохижуулах.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд оролцох байр суурийг нь сайжруулан нийгэмшүүлэх, төлөвшүүлэхэд, бие даан амьдрахад нь дадал олгох нэгдсэн төв байгуулахад нь бодлогоор дэмжинэ. (Эрүүл мэндийн дасгал сургуулалт хийх, спорт, урлагийн зарим нэг төрлөөр хичээллэх, суурь боловсрол эзэмшихэд нь туслах, ажиллах хөдөлмөрлөхд нь дадал олгох)
4. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгох хүүхдийн амьдрах, тоглох эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх.
5. Эрүүл иргэн, амьдралын зөв дадлыг дэмжсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэх
6. Сайн дурын сонирхлын клубуудын үйл ажиллагааг дэмжих замаар хувь хүний хөгжлийг дэмжих, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлэх
7. Хот төлөвлөлт, хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт болон олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа бүрт төлөвлөлтөөс нь эхлээд үр дүн гарах хүртэлх үйл явцад иргэдийн оролцбог хангах
8. Салбар хоорондын тэнцэл дээр тулгуурлан орон нутгийн төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хийгдэж буй ажил үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийхэд олон нийтийн болон ТББ-уудын ОРОЛЦООГ хангаж, сайжруулах механизмыг нэвтрүүлэх

### **Бизнес таатай хот:**

1. Бизнесийн шударга өрсөлдөөн, тэгш боломжтой байдлыг хангах замаар хамгийн таатай орчныг бүрдүүлэх
2. Төсвийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг орон нутгийн хөгжил, орон нутгийн ААН-үүдэд илүү үр өгөөжтэй болгох
3. НҮСЭР төрөөс ТӨСӨР төр байх, төрийн бүх үйлчилгээг цахимжуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэх
4. Өөрөө өөртөө ажлын байр бий болгох санаачлагыг дэмжих, дундаж давхаргыг тэгш боломж олгох нөхцөлийг бүрдүүлэх
5. Аймгийн хэмжээнд батлагдсан болон хэрэгжиж буй бодлогыг үргэлжлүүлэн үр дүнг гаргах

### **Оюунлаг залуусын хот:**

1. Бүтээлч аж үйлдвэрлэлийн салбар болон мэдээлэл технологийн тарааны бизнесийн эко системийг бүрдүүлэх
2. Мэргэжлийн боловсролын тогтолцоог аж үйлдвэрлэлийн 4 хувьсгалтай уялдуулан шинэчлэх
3. "Англи хэлтэй хот" хөтөлбөрийг аймгийн ЗДТГ, Боловсрол соёлын газар болон бусад сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах

4. Эрдэнэт хотоос гадаадад амжилттай ажиллаж суралцаж байгаа залуучуудын нөөцийг хотын хөгжилд ашиглах платформыг зохион байгуулах

Эрдэнэт 20/30/40:

1. Сайн засаглал, ил тод, улс төрөөс ангид, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүрэн нутагшуулах
2. Хангайн бүсийн төвийн хувьд бүсийн давуу тал, нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

